

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ2024 оны 11 дүгээр  
сарын 01-ний өдөр

№ 31

Улаанбаатар хот

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

**ҮНДЭСЛЭЛ:** Монгол Улсын Банкны тухай хуулийн 31.3 дугаар зүйлийн 31.3.3 дахь заалтад Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин, урамшууллын хэмжээг тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76.1 дүгээр зүйлийн 76.1.8 дахь заалтад Төлөөлөн удирдах зөвлөл компанийн Гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76.1 дүгээр зүйлийн 76.1.9 дэх заалтад Төлөөлөн удирдах зөвлөл компанийн Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.13.10 дахь заалтад Төлөөлөн удирдах зөвлөл нь Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин, урамшууллын хэмжээг тогтоох эрх, үүргийг хэрэгжүүлэхээр заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хорооны 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар Банкны Гүйцэтгэх захирлын албан тушаалд Рэнцэнбат овогтой Мөнхтуяа-г үргэлжлүүлэн ажиллуулахыг бүх гишүүд санал нэгтэйгээр дэмжиж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахаар шийдвэрлэсэн болохыг тус тус үндэслэн, **ИЙНХҮҮ:**

- ТОГТООХ НЬ:** Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хорооны саналыг үндэслэн Р.Мөнхтуяа (регистрийн дугаар: 1-г Банкны Гүйцэтгэх захирлын албан тушаалд 2024 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн үргэлжлүүлэн ажиллуулсугай.
- ТОГТООХ НЬ:** Төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлөн Гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяа-тай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний нөхцөл (болон холбогдох баримт бичиг)-ийг тохиролцон байгуулах, шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах, бусад холбогдох бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Түдэв овогтой Дарьбум-д олгосугай.

БАТЛАВ



Гудэв овогтой Дарьбум



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны  
11 дүгээр сарын 01-ний өдрийн 31 тоот тогтоол

НУУЦЛАЛТАЙ



Дашдаваа овогтой Хулан

Харада Ясунари

Цагаач овогтой Баатарсайхан

Кисабүрэй Иший

Жон Ло

Амарбаясгалан овогтой Тамир

Ханс Аарт Йончяанс

Батболд овогтой Амарсанаа



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны  
11 дүгээр сарын 01-ний өдрийн 31 тоот тогтоол

НУУЦЛАЛТАЙ

Дашдаваа овогтой Хулан

Харада Ясүнари

Цагаач овогтой Баатарсайхан



Амарбаясгалан овогтой Тамир

Ханс Аарт Йонгяянс

Батболд овогтой Амарсанаяа